



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 1,  
Утас/Факс: (976-11) 32-06-68

2020.01.09 № 2/85  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Эрдмийн баяр зохион  
байгуулах тухай


МУИС-ийн 2019-2020 оны хичээлийн жилийн өвлийн төгсөлтийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа 2020 оны 01 дүгээр сарын 15-нд зохион байгуулагдана. Эрдмийн баярын үйл ажиллагааг захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг зохион байгуулах бөгөөд бакалаврын төгсөлтийн ёслолын үйл ажиллагааг бүрэлдэхүүн сургууль тус бүр дээрээ зохион байгуулагдана.

Магистр, докторын төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа нэгдсэн байдлаар 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 09:50-11:00 цагийн хооронд хичээлийн 2 дугаар байрны А танхимд зохион байгуулах тул төгсөгчдөдөө зар мэдээлэл хүргүүлнэ үү.

Бүрэлдэхүүн сургуулиуд бакалаврын ёслолын үйл ажиллагааг магистр, докторын нэгдсэн үйл ажиллагаа зохион байгуулагдаж дууссаны дараа эхлүүлэхээр зохицуулалт хийж ажиллана уу.


Хавсралт 1... хуудас.

СУРГАЛТ, ОЮУТАН ХАРИУЦСАН  
ДЭД ЗАХИРАЛ



Б.ОЧИРХУЯГ

МУИС-ийн 2020 оны 01 дүгээр сарын 09-ны  
өдрийн 2-р дугаар албан бичгийн хавсралт



## МУИС-ИЙН ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

2019-2020 оны хичээлийн жилийн өвлийн төгсөлт

2019-2020 оны өвлийн улиралд 159 магистр, 14 докторын төгсч байна. Бакалаврын төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа Бүрэлдэхүүн сургууль тус бүр дээрээ зохион байгуулагдана.

Магистр, докторын төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа нэгдсэн байдлаар 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 09:50-11:00 цагийн хооронд МУИС-ийн хичээлийн 2 дугаар байрны А заал /343/-нд болно.

### ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР:

- 09:30 Төгсөгчид байраа эзэлнэ.
- 10:00 Ёслолын ажиллагааны нээлт, хөтлөгч нээнэ.
- 10:01 Төрийн дуулал эгшиглэнэ.
- 10:02 Урлагийн мэндчилгээ /Нийслэлийн Улаанбаатар чуулгын үндэсний хөгжмийн цөөхүүл/
- 10:05 Мэндчилгээ, МУИС-ийн Захирал Д-р. Я.Төмөрбаатар
- 10:10 Мэндчилгээ, МУИС-ийн Ахисан түвшний сургуулийн бодлогын газрын дарга Д-р Б.Энх-Амгалан үг хэлнэ.
- 10:15 Төгсөгчдөд диплом, энгэрийн тэмдэг гардуулах зочдыг урих. /МУИС-ийн Захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирлуудыг хөтлөгч тайзнаа урина./
- 10:20 Хөтлөгч төгсөгчдөд зэрэг цол олгох тушаал уншина.
- 10:25 Докторын төгсөгчдөд диплом, энгэрийн тэмдгийг гардуулна.
- 10:30 Магистрын төгсөгчдөд диплом, энгэрийн тэмдгийг гардуулна.
- 10:45 Төгсөгчийн төлөөлөл үг хэлнэ.
- 10:55 Төгсөлтийн дуу эгшиглэх.
- 11:00 Дурсгалын зураг татуулна.

ОЮУТАН, ТӨГСӨГЧИЙН ХЭЛТЭС